

ГАПЛОЛОГИЙН ХУУЛЬ БА МОНГОЛ ХЭЛНИЙ
“r” ГИЙГҮҮЛЭГЧ, “-la/le-” ҮЕИЙН СУГАРАЛ

Д.Заяабаатар¹

Хэлний хэмнэх зарчим, авиа хоорондын нөлөөгөөр утга ялгах үүрэггүй болсон авиа өгүүлэхийн явцад сулран сугардаг. Монгол хэлний сонсголонт, сул, дуутай, хэлний урдуурх, уруулын биш, хажуугийн шүргэх -l- гийгүүлэгчийн сугарлын дараах тохиолдлыг судлаачид ажиглан тэмдэглэжээ.

Эртний монгол хэлэнд -sun/-sün дагаврын өмнө байсан -l- гийгүүлэгч орчин цагийн монгол хэл, аялгуунд гол төлөв сулран сугарчээ.

‘хумс’	<	kimusu	<	*kimulsun
‘цаас’	<	čayasu	<	*čayalsun
‘мөс’	<	mösü	<	*mölsün
‘сахуус’	<	sakiyusu	<	*sakiyulsun
‘цөс’	<	sösü	<	*sölsün

Энэхүү сугарлын учир шалтгааны талаар Д.Төмөртоогоо “...зэргэлдээх авианыхаа давамгайлах нөлөөнөөс шалтгаалсан бус, харин тухайн үгийнхээ хувид утга ялгах үүргээ алдсантай холбоотой байж магадгүй юм. Эсвэл үгийн үндсэн дотор -ls- гэсэн гийгүүлэгчийн дараалал алдагдсанаас ч шалтгаалсан байж болно”² гэсэн таамаглал дэвшүүлсэн байна. “Харин үүний эсрэг тохиолдолд халхын аялгуунаа -l- нь үлдээд -sun/-sün дагавар нь үгүй болсон жишээ цөөнгүй бий.

PM. *paγalsun ‘аргал’ > Mo. aryal; Oir. argasan

PM. *koryulsun ‘хоргол’ > Mo. qoryul; Oir. xorgoson

PM. *γoduldun > *γutulsun ‘γymal’ > Mo. γutul; Oir. gosson...”³

Ийнхүү -l- гийгүүлэгч сугарах үзэгдэл монгол хэлний нутгийн аялгуу бүрд адилгүй байсан бололтой. Дундад үеийн монгол хэлний өрнөд аялгууны дурсгал “Мукаддимат ал-Адаб толь”-д čälsuči, čälsun, čälsuni niken ni’ür⁴, “Ибн Муханны толь”-д sölsün⁵ хэлбэрээр тохиолдож байгаа бол сонгодог бичгийн өмнөх монгол бичгийн

¹ Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Д.Төмөртоогоо, *Монгол хэлний түүхэн хэлзүй*, Нэгдүгээр дэвтэр, Монгол хэлний түүхэн авиа зүй, Улаанбаатар, 1992, 158-р тал.

³ Ц.Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, “Эртний монгол хэлний судлал”, Улаанбаатар, 1999, 107-р тал.

⁴ Н.Н.Поппе, *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб*, Часть I-II, Академия Наук СССР, Москва-Ленинград, 1938, стр. 131.

⁵ Мөн тэнд, стр. 446.

дурсгалд⁶ *čaya:sun* [Bod.20a9], *kimusu* [Bur.26a], *kimusun* [Bod.16a3], *mölsün* [Taq.6a2], *{saqi}yu:lsun* [Turf.32:5] гэсэн хувилбараар тохиолдоно.

Ер нь, *-l-* гийгүүлэгч зэргэлдээ авианы нөлөөгөөр сулран сугардаг хувьсал алтай хэлний нийтлэг үзэгдэл бололтой. Үгийн дунд орсон дуутай сул *-l-* гийгүүлэгч орчныхоо авианы нөлөөгөөр хэмнэгдэхийн сацуу үг, бүтээврийн утга ялгах үүргээ алдан сугардаг үзэгдэл манж хэлэнд байдаг ажээ.

[-lm-]	<i>umuxun</i>	<	<i>*ulmuxun</i> , мо. <i>ölmeu</i> 'өлмий'
[-lj-]	<i>durbejen</i>	<	<i>*dörbeljin</i> 'дөрвөлжин'
	<i>surbejen</i>	<	мо. <i>surbulji</i> 'сурвалж'
	<i>urkuji</i>	<	мо. <i>ürgülji</i> 'үргэлж'

Мөн "Дундад үеийн солонгос хэлний эхэн үед нийлмэл үгийн *n, d, z, s, j, c* зэрэг гийгүүлэгчийн өмнө байсан *l* гийгүүлэгч орчин цагийн солонгос хэлэнд сугарсан байна. Жишээ нь, **불나무* (*pilnamu*) > *부나무* (*punamu*). Дундад үеийн солонгос хэлний эрт үед **널삼* (*nolsam*) байсан бол дундад үеийн солонгос хэлний хожуу үед *너잠* (*nozam*)"⁸ болжээ. Өмөр Дэмиржан (Ömer Demircan) түрэг хэлэнд *kilitlemek* > *kitlemek* гэж *-li-* үе сугарсан тохиолдлыг гаплогийн хуулийн жишээ болгон дурджээ⁹.

Монгол хэлний *-l-* авианы түүхэн сугарлаас гадна *-l-* гийгүүлэгч бүхий хоёр үе нэгэн үгийн бүтцэд дараалан орвол аль нэг үе нь сугардаг ажээ. Ж.Санжаа "Зөв бичих дүрмийн шаардлагаар бичдэг ижил буюу ойролцоо авиануудын нэг нь хэлэхийн явцад үүрэггүй болж, хэлний хэмнэл ёсоор гээгдэнэ" гээд *байгууллага-bāegüläg, тугаллалаа-tugällä*¹⁰ зэрэг жишээ татсан байна. Энэ бол дан гагц *-l-* гийгүүлэгч бус *-la/le-* үеийн сугарлын асуудал юм.

'эмээллэлээ'	>	<i>emēllē</i>
'тугаллалаа'	>	<i>tugällä</i>
'ажиллагаа'	>	<i>adžälgā</i>

Өгүүлэхийн явцад *-la/le-* үе сугардаг эл үзэгдлийн учрыг тодруулахад хэлшинжлэлийн ухааны "гаплогийн" хэмээх ойлголт холбогдоно. Ер нь монгол хэлэн дэх гаплогийн үзэгдлийг шинжлэн тогтоох нь монгол бичгийн хэлний зөв дуудах зүйг тогтолцоотой судлах, эртний бичгийн дурсгалыг зөв уншиж ухах, гадаадын хүнд монгол хэл заан сургахад чухал ач холбогдолтой юм.

Дараалан орсон төсөө бүхий хоёр үе, авианы аль нэг нь өгүүлэхийн явцад гээгдэх ёс буюу *гаплогия, haplogy*¹¹ гэдэг хуулийг монгол хэлшинжлэлийн нэр томьёоны

⁶ Үзнэ үү: *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script* (XIII-XIV Centuries), Introduction, Transcription and Bibliography, Edited by D.Tumurtogoo With the Collaboration of G.Cecegdari, Institute of Linguistics, Academia Sinica, 2006, 722 p.

⁷ М.Баярсайхан, *Манж бичгийн хэлэн дэх гийгүүлэгчийн сугарал*, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, Боть XIX (193), Эрхэлсэн Л.Чулуунбаатар, Н.Балжинням, Улаанбаатар, 2003, 3-р тал.

⁸ 李基文, 國語史 (И Ги Мүн, *Солонгос хэлний түүхийн судалгаа*), 2001, p. 113.

⁹ Ömer Demircan, *Türkçenin sesdizimi*, Istanbul, 1996, p. 93.

¹⁰ Ж.Санжаа нар, *Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй*, Улаанбаатар, 2008, 196-р тал.

¹¹ Үзнэ үү: *Большой энциклопедический словарь*, Языкознание, Главный редактор В.Н.Ярцева, Москва, 1998, стр. 93; Д.Э.Розенталь, М.А.Теленкова, *Словарь-справочник лингвистических терминов*, Москва, 1985, стр. 50; David Crystal, *The Cambridge Encyclopedia of Language*, Second edition, Cambridge University press, 1997, p. 330.

толь бичигт *ижил авиа гээгдэхүй*¹², *давхар авиа гээгдэл, үеэрээ ондоошил*¹³ гэж орчуулсан байна. Энэ хуулийг Америкийн хэлшинжээч, санскрит судлаач Моорис Блүүмфилд (Maurice Bloomfield) 20-р зуунд анх тогтоосон гэнэ¹⁴. Хэлшинжлэлийн толь бичигт гаплогийн хуулийг дараах жишээгээр тайлбарлажээ.

'знаменосец'	<	*знаменносец
'трагикомедия'	<	*трагикокмедия
'розоватый'	<	*розововатый
'England'	<	*Englaland (English)
'nutrix'	<	*nutritrix (Latin)
'sagardo'	<	*sagarrardo (Basque)

Гаплогийн хууль ёсоор үе, авиа гээгдэх үндсэн хоёр нөхцөл байдаг. Үүнд:

1. Тухайн үе нь хүчдэлгүй;
2. Хоёр үеийн бүтэц нь адил төстэй.

Монгол хэлний тайлбар толь, зөв бичих дүрмийн тольд¹⁵ -l- гийгүүлэгч бүхий хоёр үе дараалан орсон үгсийг тэмдэглэхдээ ихэвчлэн өгүүлэхийн урсгалд -la/le- үе сугарсан хувьслыг шууд тусгах, зарим тохиолдолд үгийн бүтцийн зүй тогтлыг дагах хоёрдмол зарчим барьснаас нэг хэлзүйн хэлбэрийн хувилбарт бичлэг цөөнгүй бий болжээ. Тухайлбал:

'нүүрэлд-'	<	*нүүрлэлд-
'тээгэлд-'	<	*тээглэлд-
'хуйвалд-'	<	*хуйвлалд-
'сүүжилд-'	<	*сүүжлэлд-
'өнцгөлд-'	<	*өнцөглөлд-
'андалд-'	<	*андлалд-

гэх мэт.

Ийнхүү нүүрэлдэх~нүүрлэлдэх, андалдах~андлалдах зэрэг илтгэх утга нь ижил, бичих хэлбэр нь өөр хэлзүйн хэлбэрүүд бий болж, нэр үндсэнд -лд дагавар залгаж үйл үг үүсгэдэг мэт эргэлзээт үзэгдэл орчин цагийн монгол хэлэнд хэвшжээ. Үг бүтэх ёсны үүднээс үзвэл, жишээлэн авсан үгс 'нэр үндэс+ла'⁴(нэрээс үйл үүсгэх дагавар)+-лд (үйлдэлдэх хэвийн бүтээвэр) гэсэн бүтэцтэй болох нь илэрхий юм. Тэгвэл уг бүтцийг эвдэж нэрээс үйл үг бүтээх -ла⁴ дагаврыг гээн бичдэгийн учир юу вэ?

Монгол хэлний түүхэн дурсгалд дээрх үгстэй ижил бүтэц бүхий хэлзүйн хэлбэрийг хэрхэн тэмдэглэснийг тодруулъя.

"Монголын Нууц Товчоон", "Мукаддимат ал-Адаб" зэрэг дундад үеийн монгол хэлний дурсгал хийгээд XVII зууны гол түүхэн сурвалж бичгүүдэд нэрээс үйл бүтээх -la/-le дагаврын дараа үйлдэлдэх хэвийн -ldu/-ldü бүтээвэр орсон тохиолдолд үг бүтэх ёсны зүй тогтлын дагуу -la+ldu/-le+ldü нийлэмжээр тэмдэглэжээ.

¹² Д.Төмөртоогоо, *Хэлшинжлэлийн нэр томъёоны хураангуй толь (монгол-орос-англи)*, Улаанбаатар, 2004, 24-р тал.

¹³ Д.Энхбат, *Хэлшинжлэлийн англи-орос-монгол толь бичиг*, Улаанбаатар, 2003, 108-р тал.

¹⁴ Үзнэ үү: <http://www.absoluteastronomy.com/topics/Hapology>.

¹⁵ Ц.Дамдинсүрэн, Б.Осор, *Монгол үсгийн дүрмийн толь*, Улаанбаатар, 1983, 23, 168, 247, 301-р тал; *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*, Улаанбаатар, 2008, I боть, Ерөнхий редактор Л.Болд, 112-р тал; III боть, 1419, 1593, 1818; Y боть, 2676-р тал; III.Чоймаа нар, *Монгол хэлний хэлзүйн толь бичиг*, Улаанбаатар, 2006, 42, 536, 594, 681, 903, 1079-р тал.

- [§153]¹⁶ ... *güün-i mökōri'ülüya ke'en jasaqlalduba*
 [§156] ...*cinggis-qahan qadā sa'uju undāladurun*
 [§175] ...*to'o to'olalduba to'olaldu'asu...*
 [§232] ...*sibawulaldun abalaldun yabutuqai*
 [§254] *oron-dur-iyān ülü oron oljalaldun büle'e*
 [MA]¹⁷ *andayārtalduba tünle*¹⁸
 [MA] *andalaalduba tünle*¹⁹
 [XAT]²⁰ ...*degedün-e degere bayiralalduju*²¹
 [LAT]²² ...*tömüjin-ü arča manglai-tu yoduli araljilduju andalaaldubai*²³
 [LAT] ...*kündüleldün dayilalduy-a kemejü...*²⁴
 [ЭТ]²⁵ *sayilaldun tusalalduyсан yisün örlüg-üüd nököd minu*²⁶
 [ЭТ]...*batuda barildun andayalalduyad*²⁷

Түүнчлэн, үйлийн давтах байдлын *-la/-le* бүтээврийн дараа хэвийн *-ldu/-ldü* орсон хэлзүйн хэлбэржилтийг бичгийн хэлний зүй тогтлын дагуу *-la+ldu/-le+ldü* нийлэмжээр бичжээ.

- [§142] *bidan-u manglan teden-tür ungsilalduju*
 [XAT]...*kürči[=kürčü] čabčilalduba: čabčilalduqui-tur*²⁸
 [LAT] ...*čabčilaldun göbsileldün qayačam ta*²⁹

Эдгээр хэлзүйн нийлэмж дэх *-la/-le* үе хэлэхийн явцад сулран сугарч, орчин цагийн монгол хэлэнд *цавчилд-, уншилд-, гөвшилд-* болсон нь бодот үзэгдэл билээ.

П.Бямбасан “Иймэрхүү үгийг ажиглахад үнэхээр учрыг нь олоход бэрхтэй юм”³⁰ гээд “...үйл үг бүтээх *-л* дагаврын дараа *-лд* нөхцөл шууд залган орохоор нэг “*л*” гээгдсэн байж болох юм. Гэвч орчин цагийн хэлний үүднээс эдгээр үгэнд орсон *-лд* морфем хэвийн нөхцөлийн шинжгүй тул үг бүтээх дагавар гэж үзмээр байна”³¹ гэж тодорхойлжээ. Норжин, Тэгшдүүрэн нар нэрээс үйл үүсгэх *-lda/-lde* дагавар гэж үзээд *нуруулд-, ташаалд-, тохойлд-, буруулд-, эелд-, хажуулд-, хошуулд-, зорјулд-, жишүүлд-,*

¹⁶ “Монголын Нууц Товчоон”-ы жишээг Рахевильцийн галигаас авав. Үзнэ үү: Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, Bloomington, 1972.

¹⁷ Мукаддимат ал-Адаб.

¹⁸ Н.Н.Поппе, Мукаддимат ал-Адаб, стр. 103.

¹⁹ Мөн тэнд., стр. 103.

²⁰ “Хураангуй алтан товч”.

²¹ *Qad-un ündüsün quriyanguui altan tobči*, Эх бичгийн судалгаа, Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Ш.Чоймаа, MONUMENTA MONGOLICA: Tomus II, Centre for Mongol Studies, National University of Mongolia, Улаанбаатар, 2002, 100-р тал.

²² Лувсанданзаны “Алтан товч”.

²³ Лувсанданзан, *Эртний хаадын үндэслэсэн тор ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой*, Оршил бичсэн Ш.Бира, УТНС-д хадгалагдаж буй Лувсанданзаны гар бичмэл эхээс гэрэл зургаар бэлтгэсэн С.Төрбат, Улаанбаатар, 1990, 30а.

²⁴ Мөн тэнд., 11б.

²⁵ Сагансэцэний “Эрдэнийн товч”.

²⁶ Erich Haenisch, *Eine Urga-Handschrift des mongolischen Geschichtswerks von Secen Sagang* (alias Sanang Secen), Akademie-Verlag-Berlin, 1955, 41r5.

²⁷ Erich Haenisch, 49r5.

²⁸ *Хураангуй алтан товч*, 100-р тал.

²⁹ Мөн тэнд., 11б.

³⁰ П.Бямбасан нар, *Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулалт*, “Монгол хэлний үйл үгийн тогтолцоо”, Улаанбаатар, 1987, 63-р тал.

³¹ Мөн тэнд., 65-р тал.

дугуйлд-, хаяалд- зэрэг жишээ татжээ³². Норжин “-da/-de” хувилбарын “-lda/-lde” бол урт богино “ya, ya”-ийн аймгийн гийгүүлэгч хийгээд “i” дэвсгэрээр төгссөн үндсэнд “-da/-de” лугаа сэлгэнэ. Жишээлбэл: хажуулдах, буруулдах, өрөөлдөх, аялдах, эелдэх, таашаалдах гэх мэт.³³ гэж үзсэн нь үнэмшилгүй юм. Монгол хэлний авиа сэлгэх ёсоор “-da/-de”, “-lda/-lde” сэлгэх ямар ч боломжгүй билээ.

Орчин цагийн монгол хэлэнд хэлбэр, үүргийн хувьд шанаалд- (шанаа+лд), таашаа- (таашаа+лд), өсгий- (өсгий+лд), өхийлд- (өхий+лд), тохойлд- (тохой+лд), өлмийлд- (өлмий+лд), дунгуйлд- (дунгуй+лд) зэргээр нэрээс үйл үг үүсгэдэг -лд дагавар залгаж бүтсэн гэж үзэхүйц үгс байгаа нь бодот баримт билээ. Харин ийм бүтэцтэй үгсийг үг бүтэх ёсны зүй тогтлын дагуу нэрээс үйл үүсгэх -лд дагавар залгаж бүтсэн, эсвэл уг бүтээврийг -д дагаврын хувилбар мэтээр тайлбарлах нь оновчгүй юм.

Бидний санахад нэрээс үйл үүсгэх -лд дагаврын гарал ирлийг хэлзүйн зүй тогтлоор бус адилсалтай (analogy) холбон тайлбарлах үндэслэлтэй. Тодруулбал, нүүрлэлд-, андлалд- гэх мэтчилэн “нэр үндэс+ла⁴ (нэрээс үйл бүтээх дагавар)+лд (харилцан үйлдэх хэвийн бүтээвэр)” жишгээр бүтсэн хэлзүйн хэлбэрээс өгүүлэхийн явцад гаплогогийн хуулиар -la/-le үе сулран сугарч, өнгөн бүтцийн хувьд “нэр үндэс+лд” гэсэн загвар хэлэхүүд буй болжээ. Энэхүү загварын адилсал жишгээр нэр үндсэнд -лд бүтээвэр залгаж, үйл үг бүтээх арга монгол хэлэнд хэвшлийг олсон байна.

Нөгөөтээгүүр, өмнө эш татсан дундад үеийн монгол хэл, монгол түүхэн сурвалжийн баримтад “нэр үндэс+ла⁴+лд” гэсэн нийлэмжийг тогтолцоотой тэмдэглэснээс үзэхэд “нэр үндэс +лд(үйл үг бүтээх дагавар)” нь монгол хэлний үг бүтэх ёсны зүй тогтолт загвар бус “нэр үндэс+ла⁴+лд” хэлбэрээс өгүүлэхийн явцад -ла⁴ үе сугарсан хувьслыг шууд тусгасан үзэгдэл болох нь тодорхой ажээ. Монгол хэлний зарим тайлбар толь болоод нутгийн аялгууны толийг шүүн үзэхэд³⁴ нэрээс үйл үүсгэх -лд дагавар залгаж бүтсэн хэлзүйн хэлбэр огт тохиолдохгүй байгаа нь уг онцлог хэлэхийн урсгал дахь авианы нөлөөтөх хувьсалд холбоотой ойрхи цагийн үзэгдэл болохыг гэрчилнэ.

Монгол хэлний -la/-le үеийн сугаралд холбогдох бас нэгэн жишээ бол орчин цагийн монгол хэлний “хэл-” хэмээх үйл үндсийн түүхэн хувьсал юм. Уг үйл үндсийг “Монголын Нууц Товчоон”-д ямагт “kelele-” гэсэн хэлбэрээр тэмдэглэсэн байдаг.

[§37] *ger-tür-iyen gürü'et aqa-nar de'ü-ner keleleldüjü morilaba*

[§105] *jamuqa de'ü-de kelelejü ilē jamuqa de'ü qoyar tümet morilatuqai*

[§118] *jamuqa anda-yin keleleksen kelen*

[§149] ... *yeke dawu-'ar de'ü-ner kö'üd-iyen qailaju kelelerün...*

Үүний учрыг Ш.Чоймаа тайлбарлахдаа “Монгол хэлний үг бүтэх ёсны үүднээс үзвэл, нэр үгээс үйл үг бүтээдэг “-ла/-лэ-” дагаврыг “kele” (хэл) гэсэн нэр үгэнд залгаж, “өгүүлэх, ярих” гэсэн утгатай “kele+le+kü” гэсэн үйл үг бүтсэн нь тодорхой бөгөөд монгол бичиг маань монгол хэлний үгийн бүтцийг эвддэггүй тул эртний хэлбэрийг маш

³² Norjin, *Mongyol kelen-ü üge бүтүгекү dayaburi-yin quriyangyui*, ÖMSKKQ, 2001, 122-123; Tegsidügüireng, *Mongyol kelen-ü üge бүтүгекү yosun-u sudulul*, LUKQ, 2005, 108-р тал;

³³ Norjin, *Mongyol kelen-ü youl yosu*, ÖMSKKQ, 1987, 378-р тал.

³⁴ *Qorin naimatu tailburi toli*, Namjilm-a emkidkebe, ÖMAKQ, 1994, 2012 тал; Марал овогт Сумьяабаатар, *Гучин зургаат тайлбар толь*, I-V, Улаанбаатар, 2005, 453 тал; VI, Улаанбаатар, 2003, 493 тал; VII, Улаанбаатар, 2005, 478 тал; VIII, Улаанбаатар, 2009, 399 тал; Antoine Mostaert, *Dictionnaire Ordos*, Monumenta Serica, Journal of Oriental Studies of the Catholic University of Peking, The Catholic University-Peking, 1941, 1942, 1944; Ulaanbaatar, 2009, 950 тал.

сайн хадгалж ирсэний нэг гэрч юм. Монгол хэлний хөгжлийн явцад, ярианы хэлний нөлөөгөөр ойрхон байсан хоёр “I” авианы нэг нь суларч сугараад, өдгөөгийн “*keleki*” (хэлэх) гэдэг хэлбэр буй болжээ. Лувсанданзан бээр “*keleleki*” гэсэн хэлбэрийг бараг цөмийг засаж “*keleki*” болгосон байна”³⁵ гэж тэмдэглэсэн нь бидний ажиглалтыг үнэмшилтэй болгож байна. “Хуа И И Юй толь”-д ч “*ulus irgen-diir-iyen kelele*”³⁶ гэсэн хэлбэрээр тохиолдож буй. Шагж абугайн “Монгол үгний тайлбар толь”-д “*kelelemüi - ögülemüi kemekü üge*”³⁷, “Хорин наймт тайлбар толь” “*kelelemüi - üge učir-i iledken yaryaju, delgeregülin keleki-üi kelelemüi kememüi*”, “*kelelegči - aliba bičig sudur-i tayilburilačid-i buyu olan-i tölügen üge iledkekü kümün-i kelelegči kememüi*”³⁸ гэж оруулсан байдаг нь орчин цагийн монгол хэлний хэл- хэмээх үйл үндсийн эртний хэлбэр **kelele*- болохыг илтгэх бас нэгэн баримт юм. Н.Н.Поппе “...*kele*- нь *kelele*- хэлбэрээс үүссэн байна. *kele*- хэмээх үйл үг нь хоёр ижил үе нийлсэн хэлбэр болох юм”³⁹ гэжээ.

Монгол хэлний үгийн санд *-la/le-* үеийн сугарал, өгүүлэхийн онцлогийг шууд тусган тэмдэглэсэн, угтаа үг бүтэх ёсны зүй тогтлоос гажсан үгс бий. Энд жишээ болгож *хариулт*, *голомт* гэсэн хоёр үгийг авч үзье. Монгол хэлэнд *боо > боолт*, *барь > барилт*, *дар > даралт*, *боо > боомт*, *барь > баримт*, *дар > дарамт* гэх мэтчилэн үйлээс нэр бүтээх үүрэгтэй *-лт*, *-мт* дагавар байдаг талаар эрдэмтэд⁴⁰ судалгаандаа тодорхой дурджээ. Гэтэл нэр үндсэнд нэр үг бүтээх дагавар залгаж бүтсэн гэж тайлбарлахуйц *хариу > хариулт*, *гол > голомт* хэмээх хэлбэр үгийн сангийн бүрэлдэхүүнд нэгэнт хэвшсэн байна.

Бидний санахад *хариулт*, *голомт* гэдэг нэр үгсийн бүтцийг нэрээс нэр үүсгэх *-лт*, *-мт* дагавар залгаж үүссэн, тийм бүтээвэр байгаа мэтээр хялбарчлан үзэх бус *-la/le-* үеийн сугаралтай холбон тайлбарлах нь зүйтэй юм. Загварчлан үзүүлбэл,

<i>qariyulta</i>	>	* <i>qariyulalta</i> (<i>qariyu+la+lta</i>)
<i>хариулт</i>	>	* <i>хариулалт</i> (<i>хариу+ла+лт</i>)
<i>yolumta</i>	>	* <i>yoollamta</i> (<i>yool+la+mta</i>)
<i>голомт</i>	>	* <i>голломмт</i> (<i>гол+ло+мт</i>)

болно. Цэцэнцогт “*Асуу > асуулт* гэхээс зүйчлэн “*хариу > хариулалт > хариулт*” хэмээн задалж болмоор”⁴¹, Ш.Чоймаа “гол-голомт цуваа цагийн үүднээс авч үзвэл, гол+ло+мт байсан буй заа”⁴² гэж тэмдэглэсэн нь зөв болно.

³⁵ Лувсанданзан “*Алтан товч*”, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа, “Монгол түүхэн сурвалж бичгийн цуврал”, 7-р боть, Улаанбаатар, 2006, 65-р тал.

³⁶ Хуа И И Юй, Шинээр эмхэтгэж, галиглаж, тайлбар хийсэн Мандах, ӨМСХХ, 1998, 233-р тал.

³⁷ Šayja, *Mongyol ügen-ü tayilburi toli*, Mongyol ulus-un soyol-un sang, 1994, 367-р тал.

³⁸ Qorin naimatu tailburi toli, Namjilm-a emkidkebe, ӨМАКQ, 1994, 890-р тал.

³⁹ Николас Поппе, *Алтайн хэлиин жэлэлийн удиртгал*, Орчуулсан В.Энхболд, Л.Жумдаан, Улаанбаатар, 1999, 252-253.

⁴⁰ Ц.Онорбаян, *Орчин цагийн монгол хэлний үгзүй*, Улаанбаатар, 2004, 39-р тал; Ш.Чоймаа, *Орчин цагийн монгол хэлний үг бүтэх ёс*, “Орчин цагийн монгол хэл”, Ерөнхий редактор С.Мөөмөө, Улаанбаатар, 1997, 174, 177-р тал;

⁴¹ *Mongyol üges-ün ijayur-un toli*, Sečenčoytu nayirayulba, ӨМАКQ, 1988, 2687-р тал.

⁴² Ш.Чоймаа, *Орчин цагийн монгол хэлний үг бүтэх ёс*, “Орчин цагийн монгол хэл”, Ерөнхий редактор С.Мөөмөө, Улаанбаатар, 1997, 174-р тал.

Өгүүлэн буй сэдэвт холбогдох бас нэгэн зүйл бол *барьц-, өгц-* зэрэг үйл үндэс дэх *-ц-* бүтээврийн гарал хувьсал юм. П.Бямбасан “Харилцан үйлдэх хэвд байгаа мэт боловч энэ үзэгдлийн зүй ёсонд үл нийцэх гэмээр, монгол хэлний судалгааны эдүгээгийн хэрэглэгдэхүүн дээр түшиглэн тайлбарлахад бэрхшээлтэй: *Хөндөлдөх, бухалдах, араалдах, цухалдах, тахиралдах, хажуулдах, цоолдох, тасалдах, хэрэлдэх, доголдох, хуралдах, зохицолдох, барьцалдах, авцалдах, хөөцөлдөх, орооцолдох, өгцөлдөх, шахцалдах, маргацалдах, булаацалдах, уралдах* гэх мэт нэлээд үг байна...” гээд “*Булаацалдах* мэт үгэнд байгаа *-ц* бол хамтран үйлдэх хэвийн *-лц* нөхцөлийн *-ц* юм. Нэгэн үгэнд хамтран үйлдэх хэвийн *-лц*, харилцан үйлдэх хэвийн *-лд* нөхцөл нэг доор давхарлан орохоор (*-лц+лд*) хамтран үйлдэх хэвийн нь нөхцөлийн *л* гээгдээд *ц* нь үлдсэн гэж бодож байна”⁴³ гэж үзсэн нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, үйл үндсэнд залгадаг *-ц* бүтээврийн гарлыг үйлдэлцэх хэвийн *-лц-* бүтээврийн “*-л-*” гийгүүлэгч сулран сугарснаас үүдэлтэй гэж үзэх боломжтой юм.

<i>барьц-</i>	<	<i>bariĉa-</i>	<	<i>*barilĉa-</i>
<i>‘харьц-’</i>	<	<i>qariĉa-</i>	<	<i>*qarilĉa-</i>
<i>‘солбиц-’</i>	<	<i>solbiĉa-</i>	<	<i>*solilĉa-</i>
<i>‘харгац-’</i>	<	<i>qaryuĉa-</i>	<	<i>*qaryulĉa-</i>
<i>‘авц-’</i>	<	<i>abĉa-</i>	<	<i>*abulĉa-</i>
<i>‘өгц-’</i>	<	<i>ögĉe-</i>	<	<i>*öggülĉe-</i>
<i>‘шахац-’</i>	<	<i>siqaĉa-</i>	<	<i>*siqalĉa-</i>
<i>‘булаац-’</i>	<	<i>buliyaĉa-</i>	<	<i>*buliyalĉa-</i>

Харин хамтран үйлдэх хэвийн *-лц* нөхцөлийн *-л* гийгүүлэгч сулран сугарснаас үүдэж үүссэн *-ц* бүтээврийг “Монголын Нууц Товчоон”-д “*qasar minu qabu gücü erdemtü tula qarbucaju qaruqsan-i qarbuju*” [§244], “*cinggis-qahan qol cerik darucaju*” [§247] зэргээр тохиолдож буй дундад үеийн монгол хэлний үйлээс үйл үүсгэх *-ĉa/-ĉe* дагавар⁴⁴-тай хутгаж болохгүй.

Онцлон сонирхож буй *-la/le-* үеийн сугарал, монгол хэлэн дэх гаплогийн үзэгдэлтэй холбогдох бас нэг асуудал бол *тариалан, хүрээлэн* зэрэг үгийн бүтэц юм. Ц.Шагдарсүрэн эдгээр үгийн бүтцийг *тариа+ла+лан(г)*, *хүрээ+лэ+лэн(г)* гэж задлаад гаплогийн хуулиар *-ла*⁴ үе сугарсан гэж үзсэн бөгөөд “Ийм маягаар үүссэн үгэсийг ажихад, тухайн нэр үндсэнд *-ла*² дагавар залган орж үйл үндэс болгоод, хойноосоо орох *-лан(г)*² дагавартай холбож өгөхдөө, өгүүлэхийн явцад магадгүй өөрөө сугарч орхигддогийг дээрхи олон жишээ харуулж байна уу гэж эрхгүй санагдана. Цаашид нарийвчилан судлавал зохино”⁴⁵ гэжээ.

Эдгээр үгийн бүтцийг тайлбарлах хэд хэдэн үндэслэл байж болох юм. Үүнд:

1. Орчин цагийн монгол хэлний үгзүйн чиглэлээр гарсан зарим бүтээлд⁴⁶ дурдсанчлан нэрээс нэр үг бүтээх *-лан*⁴ дагавар залгаж, *заль+лан, хүрээ+лэн, тариа+лан, шүд+лэн, соёо+лон, дугуй+лан, эгишг+лэн, эд+лэн* (Нэр→Нэр) гэж бүтсэн;

⁴³ П.Бямбасан нар, *Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулалт*, “Монгол хэлний үйл үгийн тогтолцоо”, Улаанбаатар, 1987, 65-р тал.

⁴⁴ Qasbaγan-a, Dumdadu jayun-u mongyol kelen-ü sudulul, ÖMSKKQ 1996, 339-р тал.

⁴⁵ Ц.Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан...*, Улаанбаатар, 2007, 167-р тал.

⁴⁶ *Орчин цагийн монгол хэл*, Улаанбаатар, 1997, 167-р тал; Ц.Өнөрбаян, *Орчин цагийн монгол хэлний үгзүй*, Улаанбаатар, 2004, 35-р тал; *Орчин цагийн монгол хэл*, Улаанбаатар, 2004, 118-р тал.

2. *Зов-+лон, жарга-+лан, хяс-+лан, зус-+лан, орч-+лон, хад-+лан, хүс-+лэн* зэрэг үгийн жишгээр *залил-+лан, хүрээл-+лэн, тариал-+лан, шүдлэ-+лэн, соёол-+лон, дугуйл-+лан, эгшиглэ-+лэн, эдлэ-+лэн* (Нэр→Үйл→Нэр) гэхчилэн үйлээс нэр бүтээх *-лан*⁴ дагавар залгаж бүтсэн, *'нэр үндэс+ла*⁴(нэрээс үйл үг бүтээх дагавар)+*лан*⁴(үйлээс нэр үг бүтээх дагавар)' загвараас гаплогогийн хуулиар *-ла*⁴ үе нь сугарсан;
3. *Гасал-+н, шанал-+н* зэрэг үгийн жишгээр *залил-+н, хүрээл-+н, тариал-+н, шүдлэ-+н, соёол-+н, дугуйл-+н, эгшиглэ-+н, эдлэ-+н* (Нэр→Үйл→Нэр) гэхчилэн үйлээс нэр бүтээх *-н (-ng)* дагавар залгасан;
4. Зарим хэсэг нь *'нягтлан бодох, үзүүлэн таниулах, сурган хүмүүжүүлэх'* зэрэг холбоо үгийн арын үг орхигдсоноос *'нягтлан, үзүүлэн, сурган'* гэхчилэн жинхэнэ нэр болдог жишгээр *'залилан мэхлэх→залилан', 'урлан бүтээх→урлан'* болсон;

Дээрх үгсийн бүтцийн тухайд хоёр зүйл гаргалгаа хийж болох юм. Хэрэв монгол хэлний нэр үг бүтэх тогтолцооны дагуу үүссэн гэж үзвэл гурав дахь хувилбар *'нэр→үйл→нэр'* буюу *'нэр язгуур+ла*⁴- (үйл үг бүтээх дагавар)+*н* (нэр үг бүтээх дагавар) гэсэн загвараар бүтсэн гэж үзэх үндэстэй. Нөгөөтээгүүр, үг бүтэх ёсны зүй тогтлыг зөрчиж, нэр үндсэнд *-лан*⁴ дагавар залгаж, адилслаар үүссэн байж болно. Н.Н.Поппе "Ер түрэг хэлэнд нэрийн үндсэнд дагах залгавар бүтээврийг үйлийн үндсэнд залгаж болдоггүй ерөнхий хуультай. Үүний нэг адил үйл үндсэнд залгадаг бүтээврийг нэрийн үндсэнд залгах боломж байхгүй юм. Энэ байдал монгол хэлний хувьд ч адил байна" ⁴⁷ гэсэн нь бүтээврийн байрлал, утга үүрэг, гарал хувьслыг судлахад анхаарууштай зүйл болно.

Өгүүлэхийн явцад гарсан аливаа авианы хувьсал өөрчлөлтийг бичгийн хэлний зөв бичих зүйд тэр бүр тусган тэмдэглэдэггүй. Өөрөөр хэлбэл, хэлж ярьдаг дуудлагаараа бичих эрхийг зөв бичих зүйн хэм хэмжээ хязгаарлана гэсэн үг. Зөв бичих зүй нь *авиазүй, үгзүй, бэлгэ тэмдэг, түүхэн уламжлалт* гэсэн хэдэн зарчимд тулгуурлах боловч эдгээрийн дотроос үгзүйн зарчим залгамал хэлний бүтцэд илүү тохирдог ажээ. Тэгвэл монгол хэл залгамал хэвшинжтэй учир үг бүтэх ёсны зүй тогтол, үгзүйн зарчмыг зөв бичих зүйд чухалчлах ёстой болно. Ийм учраас өгүүлэхийн явцад гаплогогийн хууль ёсоор сулран сугарсан *-la/-le* гийгүүлэгч бүхий үеийг монгол бичгийн хэлний журамласан толь бичиг тэргүүтэнд үгийн бүтцийн дагуу сэргээн бичих нь зүйтэй юм.

Дүгнэн хэлбэл, нэрээс үйл үүсгэх *-ла*⁴ (*-la/-le*) дагаврын дараа үйлдэлдэх хэвийн *-лэ* (*-ldu/-ldü*) бүтээвэр орсон хэлзүйн нийлэмжээс өгүүлэхийн явцад хүчдэлгүй *-ла*⁴ үе сугардаг байна. Улмаар өнгөн бүтцийн хувьд нэр үндсэнд *-лэ* бүтээврийг шууд залгах нөхцөл хэлэхийн цуваанд бүрэлдэж, үүний адилслаар үйл үг бүтээх гажуудал монгол хэлний үг бүтэх ёсонд хэвшсэн бололтой. Энэ нь аливаа бүтээврийн утга, үүрэг үгзүйн зүй тогтлоос гадна өгүүлэхийн нөлөө тусгал, хэлэхийн адилслаар хэвшин тогтдогийг илтгэх бөгөөд ийм өвөрмөц үзэгдэл монгол хэлэнд байгааг харуулж буй хэрэг юм.

Эцэст тэмдэглэхэд аливаа бүтээвэр, үг, өгүүлбэрийн бүтэц, хувьсал, хэрэглээг түүхэн хөгжлийн үүднээс улируулан шинжлэх нь монгол хэл судлалын зарим ээдрээтэй асуудлын учир зангилааг зөв тайлахад илүү дөхөмтэй гэж бодож байна.

⁴⁷ Николас Поппе, *Алтайн хэлчинжлэлийн удиртгал*. Орчуулсан В.Энхболд, Л.Жумдаан, Улаанбаатар, 1999, 252-р тал.

SUMMARY

The author analyzes the issue of dropping of syllable $-la^4$. A syllable $-la^4$ eliminates when morpheme $-ld$ ($-ldu/-ldü$) of passive voice occurs after it. By the surface structure in speech, morpheme $-ld$ agglutinates to the noun stem, for analogy the deficiency of verb formation might have formed in Mongolian.

It is formed not only function and meaning of morpheme and morphological regularity but also the effect, reflection, speech analogy of articulation. It is proper to re-study some complicated questions of the Mongolian studies connected to morpheme, lexis and sentence structure by the historical development.